



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/095/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг:
boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны
Б.Бадамцэцэг

Утас: 99062042

Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОА-2025/095/НА-СТА-ТШЗ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН
ДАРГА З.БАТСҮЛД ТАНАА

2025.02.19 № 2142

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газар баруун бүс дэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газар баруун бүс дэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаалаар хилийн боомт, орон нутаг ажилласны 5 жилийн мөнгөн урамшуулалд 40.3 сая, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад хөдөө орон нутгийн нэмэгдэлд 11.3 сая, онцгой нөхцөлийн нэмэгдэлд 45,6 сая, хоолны хөнгөлөлтөд 155,3 сая төгрөгийг тус тус улсын төсвөөс олгожээ.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр, тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийг 87.5 хувийн биелэлтэй гэж дээд шатны төсвийн захирагчаас дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,093,125.32</u>	<u>76,141,892.70</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	71,093,125.32	76,141,892.70
354	Хангамжийн материал	71,093,125.32	76,141,892.70
35410	Бичиг хэргийн материал	5,063,280.00	4,880,000.00
35420	Аж ахуйн материал	14,215,600.00	14,385,600.00
35440	Түлш, шатах тослох материал	19,809.12	3,652,895.00
35450	Барилгын засварын материал	405,000.00	405,000.00
35470	Бусад хангамжийн материал	51,389,436.20	52,818,397.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>235,724,416.66</u>	<u>366,502,113.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	235,724,416.66	366,502,113.76
392	Биет хөрөнгө	223,724,416.66	331,589,613.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	91,129,723.99	91,129,723.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,969,819.65)	(21,826,030.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	221,300,000.00	209,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(85,873,610.93)	(90,169,444.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,715,873.14	96,612,733.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(70,837,222.64)	(34,206,272.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,041,498.54	99,194,277.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,782,025.79)	(18,645,374.56)
393	Биет бус хөрөнгө	12,000,000.00	34,912,500.00
39301	Програм хангамж	1,980,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,980,000.00)	(577,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,000,000.00	34,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>306,817,541.98</u>	<u>442,644,006.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,720,385.20</u>	<u>827,233.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,720,385.20	827,233.00
413	Өглөг	3,720,385.20	827,233.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	720,000.00	827,233.00
4136	Бусад өглөг	3,000,385.20	-
41361	Байгууллагад төлөх өглөг	3,000,385.20	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>303,947,123.67</u>	<u>441,816,773.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	303,947,123.67	441,816,773.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,000,000.00	34,500,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	12,000,000.00	34,500,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	289,108,642.47	404,478,292.26
51210	Өмнөх үеийн үр дүн	379,875,449.62	288,328,596.77
51220	Тайлант үеийн үр дүн	(90,766,807.15)	116,149,695.49

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,838,481.20	2,838,481.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>307,667,508.87</u>	<u>442,644,006.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	838,911,971.78	1,456,481,365.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,059,271.78	179,659,265.47
120	Нийтлэг татварын бус орлого	21,059,271.78	179,659,265.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,059,271.78	179,659,265.47
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,059,271.78	179,659,265.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	817,852,700.00	1,276,822,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	811,852,700.00	1,276,822,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	811,852,700.00	1,276,822,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	922,784,777.04	1,337,562,069.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	922,784,777.04	1,337,562,069.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	795,326,400.25	1,199,680,253.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	555,467,531.37	902,792,380.13
210101	Үндсэн цалин	345,760,460.33	431,735,358.01
210102	Нэмэгдэл	89,699,606.36	244,428,901.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,276,549.85	175,317,729.62
210104	Урамшуулал	35,730,914.83	51,310,390.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,002,518.24	114,067,993.45
210201	Тэтгэврийн даатгал	51,852,165.22	78,021,246.95
210202	Тэтгэмжийн даатгал	5,337,088.29	8,991,771.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,216,870.59	4,509,162.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,054,217.61	4,509,162.58
210205	Эрүүл мэндийн даатгал	10,542,176.53	18,036,650.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,831,085.20	50,572,144.95
210301	Гэрэл, цахилгаан	12,465,600.00	4,910,405.81
210302	Түлш, халаалт	6,494,985.20	42,344,954.14
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	766,785.00
210304	Байрны түрээс	10,870,500.00	2,550,000.00

Гадаадын иргэн харьяатын газрын Баруун бүс дэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	70,180,214.33	38,291,226.41
210401	Бичиг хэрэг	2,324,210.00	6,572,293.48
210402	Тээвэр, шатахуун	15,630,968.00	22,243,132.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	881,549.60	1,225,800.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,202,950.00	8,250,000.00
210408	Бараа материал акталсны зардал	48,140,536.73	
2105	Нормативт зардал	-	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,100,000.00	9,362,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,050,000.00
210604	Урсгал засвар	2,100,000.00	8,312,000.00
2107	Томиллолт, зочны зардал	1,452,000.00	4,134,850.00
210702	Дотоод албан томиллолт	1,452,000.00	4,134,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,242,573.05	7,330,936.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		222,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	643,200.00	910,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,748.00	215,248.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,950,000.00	5,190,700.00
210807	Газрын төлбөр	512,326.00	225,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,821,299.05	468,988.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,050,478.06	72,828,721.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	478,300.00	3,388,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	523,200.00	452,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,048,978.06	68,988,721.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,458,376.79	137,881,816.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,700,010.00	46,112,628.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	5,760,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,700,010.00	40,352,628.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	69,758,366.79	91,769,188.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,758,366.79	91,769,188.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(83,872,805.26)	118,919,295.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,743,968.78	2,769,600.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,672,618.78	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,071,350.00	2,769,600.00

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,743,968.78)	(2,769,600.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(91,616,774.04)</u>	<u>116,149,695.49</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	379,875,449.62	394,713,930.82
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	379,875,449.62	394,713,930.82
C07	Тайлант үеийн үр дүн			-91,616,774.04	-91,616,774.04
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	288,258,675.58	303,097,156.78
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	196,641,901.54	303,097,156.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	69,921.19	69,921.19
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,500,000.00	2,838,481.20	288,328,596.77	325,667,077.97
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	22,500,000.00	0.00	0.00	22,500,000.00
D08	Тайлант үеийн үр дүн			116,149,695.49	116,149,695.49
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,000,000.00	2,838,481.20	404,478,292.26	441,816,773.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>817,852,700.00</u>	<u>1,276,822,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	817,852,700.00	1,276,822,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	811,852,700.00	1,276,822,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	811,852,700.00	1,276,822,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	-

ХОА-2025/095/НА-СТА-ТШЗ

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	748,094,333.21	1,180,139,911.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	748,094,333.21	1,180,139,911.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,739,323.21	1,134,027,283.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	555,467,531.37	902,685,147.13
210101	Үндсэн цалин	345,760,460.33	431,628,125.01
210102	Нэмэгдэл	89,699,606.36	244,428,901.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,276,549.85	175,317,729.62
210104	Урамшуулал	35,730,914.83	51,310,390.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,627,518.24	114,067,993.45
210201	Тэтгэврийн даатгал	51,477,165.22	78,021,246.95
210202	Тэтгэмжийн даатгал	5,337,088.29	8,991,771.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,216,870.59	4,509,162.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,054,217.61	4,509,162.58
210205	Эрүүл мэндийн даатгал	10,542,176.53	18,036,650.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,830,700.00	53,572,530.15
210301	Гэрэл, цахилгаан	12,465,600.00	4,910,405.81
210302	Түлш, халаалт	3,494,600.00	45,345,339.34
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	766,785.00
210304	Байрны түрээс	10,870,500.00	2,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,281,099.60	39,202,814.29
210401	Бичиг хэрэг	2,098,600.00	5,999,013.48
210402	Тээвэр, шатахуун	10,945,000.00	23,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	881,549.60	1,225,800.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,355,950.00	8,178,000.00
2105	Нормативт зардал	-	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,100,000.00	9,362,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,050,000.00
210604	Урсгал засвар	2,100,000.00	8,312,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,452,000.00	4,134,850.00
210702	Дотоод албан томилолт	1,452,000.00	4,134,850.00

Гадаадын иргэн харьяатын газрын Баруун бүс дэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,000,274.00	6,861,948.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		222,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	643,200.00	910,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,748.00	215,248.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,500,000.00	5,190,700.00
210807	Газрын төлбөр	512,326.00	225,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	29,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	980,200.00	3,840,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	457,000.00	3,388,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	523,200.00	452,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,355,010.00	46,112,628.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,355,010.00	46,112,628.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,655,000.00	5,760,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,700,010.00	40,352,628.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	69,758,366.79	96,682,188.98
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,913,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,913,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,913,000.00
222001	Тоног төхөөрөмж		4,913,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(4,913,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	69,758,366.79	91,769,188.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,276,822,100.00	1,185,052,911.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,276,822,100.00	1,185,052,911.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,229,822,100.00	1,138,940,283.02

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	969,433,900.00	902,685,147.13
210101	Үндсэн цалин	436,567,600.00	431,628,125.01
210102	Нэмэгдэл	264,947,000.00	244,428,901.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	176,045,700.00	175,317,729.62
210104	Урамшуулал	91,873,600.00	51,310,390.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,304,300.00	114,067,993.45
210201	Тэтгэврийн даатгал	80,926,900.00	78,021,246.95
210202	Тэтгэмжийн даатгал	10,844,300.00	8,991,771.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,172,200.00	4,509,162.58
210204	Ажилгүйдлийн даатгал	5,172,200.00	4,509,162.58
210205	Эрүүл мэндийн даатгал	19,188,700.00	18,036,650.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,038,100.00	53,572,530.15
210301	Гэрэл, цахилгаан	11,552,300.00	4,910,405.81
210302	Түлш, халаалт	51,291,800.00	45,345,339.34
210303	Цэвэр, бохир ус	1,594,000.00	766,785.00
210304	Байрны түрээс	2,600,000.00	2,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,778,000.00	39,202,814.29
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	5,999,013.48
210402	Тээвэр, шатахуун	23,800,000.00	23,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,225,800.81
210404	Ном, хэвлэл	8,178,000.00	8,178,000.00
2105	Нормативт зардал	300,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,575,000.00	14,275,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,913,000.00	4,913,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,350,000.00	1,050,000.00
210604	Урсгал засвар	8,312,000.00	8,312,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,137,000.00	4,134,850.00
210702	Дотоод албан томилолт	6,137,000.00	4,134,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,367,800.00	6,861,948.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	222,000.00	222,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	910,000.00	910,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	216,800.00	215,248.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	99,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	5,200,000.00	5,190,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,888,000.00	3,840,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,388,000.00	3,388,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	452,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,000,000.00	46,112,628.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,000,000.00	46,112,628.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,800,000.00	5,760,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,200,000.00	40,352,628.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,276,822,100.00	1,185,052,911.02
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,276,822,100.00	1,185,052,911.02
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,276,822,100.00	1,185,052,911.02
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	25.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	7.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар 1 зөрчил¹ илэрснээс, 1 зөвлөмж өгсөн.

3.1 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтөөс шалтгаалан бараа үйлчилгээний бусад, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлуудаас эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Монгол Улсын сангийн сайдын 2023 оны 11 сарын 20-ны 211 тоот тушаалтай нийцээгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Монгол Улсын сангийн сайдын 2023 оны 11 сарын 20-ны өдрийн 211 тоот тушаалаар батлагдсан эдийн засгийн шинэчилсэн ангилал мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

